



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХЭА-2022/139/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2022 он</p>	<p>Аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112</p> <p>Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390</p> <p>Аудитор: Х.Еркегүл Утас: 99040705</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	1
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	1
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	2
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	3
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл .....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	7
3.4 Материаллаг байдал .....	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал .....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	10
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	10
4. Аудитын илрүүлэлт .....	11
4.2.1 Залруулсан алдаа.....	11
4.2.2 Албан шаардлага .....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	11
6. Албан шаардлага .....	14

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг бар  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.03.04 № 74

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

023030090

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны кол	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэ	Эцсийн үлдэгдэ
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>39,010,689.21</b>	<b>165,511,797.32</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>10,917,094.55</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	10,917,094.55
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	10,917,094.55
31211	Төрийн сангийн харилцах	-	10,905,065.55
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	12,029.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>253,060.60</b>	<b>65,681,170.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	253,060.00	186,570.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		65,494,600.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	0.60	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.60	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>38,757,628.61</b>	<b>88,913,532.77</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	14,854,778.61	60,747,888.77
35110	Тусгай зориулалттай материал	654,100.00	3,748,104.97
35130	Эм боох материал	14,200,678.61	56,999,783.80
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	23,902,850.00	28,165,644.00
35410	Бичиг хэргийн материал	879,320.00	1,182,020.00
35420	Аж ахуйн материал	2,023,300.00	2,749,500.00
35440	Түлш, шатах тослох материал	865,480.00	1,493,100.00
35450	Барилгын засварын материал	1,056,000.00	-
35460	Хүнсний материал	1,007,550.00	2,051,824.00
35470	Бусад хангамжийн материал	18,071,200.00	20,689,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>443,950,776.47</b>	<b>436,675,282.88</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	443,950,776.47	436,675,282.88
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	424,422,776.47	417,147,282.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	374,314,893.00	374,314,893.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,584,722.56)	(24,801,217.84)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,500,000.00	31,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,962,500.00)	(21,127,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,200,312.83	94,504,016.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,116,227.88)	(46,875,382.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,658,940.96	29,372,940.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,587,919.88)	(19,740,466.67)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	19,528,000.00	19,528,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,528,000.00	19,528,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>482,961,465.68</b>	<b>602,187,080.20</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>8,522,828.07</b>	<b>1,880,614.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	8,522,828.07	1,880,614.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	8,522,828.07	1,880,614.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	157,518.07	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,791,922.00	1,880,614.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	4,573,388.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	4,573,388.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>474,438,637.61</b>	<b>600,306,466.20</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	474,438,637.61	600,306,466.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	470,337,052.99	470,337,052.99
51101	Өмч: - төрийн	470,337,052.99	470,337,052.99
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(6,157,149.68)	119,710,678.91
51210	Өмнөх үеийн үр дүн	(6,157,149.68)	(6,157,149.68)
51220	Тайланг үеийн үр дүн	-	125,867,828.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,258,734.30	10,258,734.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>482,961,465.68</b>	<b>602,187,080.20</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>355,859,459.30</b>	<b>591,267,812.53</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,656,331.50</b>	<b>45,854,578.53</b>
Нийтлэг татварын бус орлого	22,656,331.50	45,854,578.53
Төсөв байгууллагын өөрийн орлого	22,656,331.50	45,854,578.53
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,656,331.50	45,854,578.53
Бусад орлого	-	-
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>333,203,127.80</b>	<b>545,413,234.00</b>
Улсын төвлөрсөн төсвөөс	281,171,400.00	324,268,400.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	281,171,400.00	324,268,400.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>20,366,807.80</b>	<b>169,968,974.00</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	167,109,986.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,366,807.80	2,858,988.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>21,713,900.00</b>	<b>29,409,600.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,713,900.00	29,409,600.00
<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>9,951,020.00</b>	<b>21,766,260.00</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,951,020.00	21,766,260.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>381,069,152.76</b>	<b>465,399,983.94</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>381,069,152.76</b>	<b>465,399,983.94</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>369,855,821.12</b>	<b>439,059,556.36</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>208,330,057.00</b>	<b>238,599,212.85</b>
Үндсэн цалин	121,132,237.00	133,097,393.50
Нэмэгдэл	71,317,674.00	91,553,401.04
Унаа хоолны хөнгөлөлт	1,442,022.00	-
Урамшуулал	14,438,124.00	11,453,858.38
Гэрээт ажлын хөлс	-	2,494,559.93
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,583,231.67</b>	<b>31,107,766.13</b>
Тэтгэврийн даатгал	18,408,354.51	21,718,781.53
Тэтгэмжийн даатгал	2,077,043.29	2,253,876.32
ҮОМШӨ-ний даатгал	1,538,535.82	1,902,695.34
Ажилгүйдлийн даатгал	487,964.47	475,674.32
Эрүүл мэндийн даатгал	4,071,333.58	4,756,738.62
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,945,087.76</b>	<b>22,193,134.42</b>
Гэрэл, цахилгаан	2,754,377.76	2,453,422.42
Түлш, халаалт	19,054,994.00	17,822,254.00
Цэвэр, бохир ус	1,135,716.00	1,917,458.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,255,898.52</b>	<b>16,886,460.00</b>
Бичиг хэрэг	2,608,000.00	2,195,950.00
Тээвэр, шатахуун	7,521,040.00	11,638,040.00
Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	1,012,040.00	1,308,520.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	300,450.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,900.00	1,383,500.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	-	60,000.00
Бараа материал акгалсны зардал	1,763,918.52	-
<b>Нормативт зардал</b>	<b>46,861,331.91</b>	<b>85,244,582.81</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,425,516.91	74,128,806.81
Хоол, хүнс	5,146,715.00	7,484,076.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,289,100.00	3,631,700.00
<b>Эд хөгшил, урсгал засварын зардал</b>	<b>2,317,600.00</b>	<b>2,931,650.00</b>
Урсгал засвар	2,317,600.00	2,931,650.00
<b>Томилголт, зочны зардал</b>	<b>950,000.00</b>	<b>1,626,500.00</b>
Дотоод албан томилолт	950,000.00	1,626,500.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,895,694.00</b>	<b>7,972,253.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,293,154.00	7,275,438.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
Даатгалын үйлчилгээ	95,400.00	81,675.00
Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	52,500.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
Газрын төлбөр	97,640.00	97,640.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,716,920.26</b>	<b>32,497,997.15</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,266,400.00	3,204,800.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,000.00	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,420,520.26	29,293,197.15
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,213,331.64</b>	<b>26,340,427.58</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>360,000.00</b>	<b>26,340,000.00</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	360,000.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26,340,000.00
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>9,900.24</b>	<b>427.58</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	9,900.24	427.58
<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,843,431.40</b>	<b>-</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	10,843,431.40	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(25,209,693.46)</b>	<b>125,867,828.59</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(25,209,693.46)</b>	<b>125,867,828.59</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,337,052.99	10,258,734.30	(6,157,149.68)	-	474,438,637.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	470,337,052.99	10,258,734.30	(6,157,149.68)	-	474,438,637.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,337,052.99	10,258,734.30	(6,157,149.68)	-	474,438,637.61
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	470,337,052.99	10,258,734.30	(6,157,149.68)	-	474,438,637.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	470,337,052.99	10,258,734.30	(6,157,149.68)	-	474,438,637.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	125,867,828.59	-	125,867,828.59
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,337,052.99	10,258,734.30	119,710,678.91	-	600,306,466.20

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>333,203,127.80</b>	<b>479,918,634.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>333,203,127.80</b>	<b>479,918,634.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	281,171,400.00	324,268,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	281,171,400.00	324,268,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,366,807.80	110,963,974.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчиг бус этгээдээс авсан хандив, тусламж		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	108,104,986.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,366,807.80	2,858,988.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	21,713,900.00	29,409,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,713,900.00	29,409,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	9,951,020.00	15,276,660.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,951,020.00	15,276,660.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>330,303,127.80</b>	<b>458,987,539.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>330,303,127.80</b>	<b>458,987,539.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>318,729,795.36</b>	<b>432,647,111.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	208,852,693.00	240,298,363.84
210101	Үндсэн цалин	140,947,161.85	151,055,765.00
210102	Нэмэгдэл	51,537,900.00	66,479,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,551,021.46	4,054,940.43
210104	Урамшуулал	13,816,609.69	14,591,491.21
210105	Гэрээт ажлын хөлс	-	4,116,367.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,150,935.60	30,013,080.61
210201	Тэтгэврийн даатгал	18,129,365.27	20,815,685.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,008,693.37	2,302,498.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,546,129.48	1,838,639.02
210204	Ажигүйдийн даатгал	419,121.89	459,659.65
210205	Эрүүл мэндийн даатгал	4,047,625.59	4,596,597.78
<b>2103</b>	<b>Байр ашиглагтай холбоотой тогтмол зардал</b>	17,625,699.76	26,766,522.42
210301	Гэрэл, цахилгаан	2,754,377.76	2,453,422.42
210302	Түлш, халаалт	13,735,606.00	22,395,642.00
210303	Цэвэр, бохир ус	1,135,716.00	1,917,458.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,172,660.00	18,904,180.00
210401	Бичиг хэрэг	2,024,500.00	2,499,650.00
210402	Тээвэр, шатахуун	8,386,520.00	12,253,160.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	1,012,040.00	1,308,520.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	448,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	399,600.00	2,394,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27,529,281.00	99,956,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,190,191.00	86,949,350.00
210502	Хоол, хүнс	5,057,090.00	8,317,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,282,000.00	4,689,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,078,300.00	4,470,650.00
210601	Багаж, техник хэрэгсэл	-	1,828,000.00
210604	Урсгал засвар	4,078,300.00	2,642,650.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	950,000.00	1,626,500.00
210702	Дотоод албан томилолт	950,000.00	1,626,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,809,326.00	7,458,815.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,206,786.00	6,762,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	97,640.00	97,640.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,560,900.00	3,152,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,560,900.00	3,152,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,573,332.44</b>	<b>26,340,427.58</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	360,000.00	26,340,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	360,000.00	26,340,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	369,901.04	427.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	369,901.04	427.58
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	10,843,431.40	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,843,431.40	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,900,000.00</b>	<b>20,931,094.55</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,900,000.00</b>	<b>10,014,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,900,000.00</b>	<b>10,014,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	2,900,000.00	10,014,000.00
223001	Бусад хөрөнгө	2,900,000.00	10,014,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(2,900,000.00)</b>	<b>(10,014,000.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	10,917,094.55
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	10,917,094.55

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайланг оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	372,914,400.00	358,049,166.87
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	372,914,400.00	358,049,166.87
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	372,374,400.00	357,509,166.87
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	246,549,700.00	239,510,401.84
210101	Үндсэн цалин	150,066,700.00	150,267,803.00
210102	Нэмэгдэл	66,479,800.00	66,479,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.00	4,054,940.43
210104	Урамшуулал	20,897,000.00	14,591,491.21
210105	Гэрээт ажлын хөлс	4,570,200.00	4,116,367.20
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,501,900.00	29,836,467.61
210201	Тэтгэврийн даатгал	23,758,200.00	20,639,072.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,900.00	2,302,498.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,948,800.00	1,838,639.02
210204	Ажилгүйдлийн даатгал	487,200.00	459,659.65
210205	Эрүүл мэндийн даатгал	4,871,800.00	4,596,597.78
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,766,600.00	26,766,522.42
210301	Гэрэл, цахилгаан	2,453,500.00	2,453,422.42
210302	Тулш, халаалт	22,431,400.00	22,395,642.00
210303	Цэвэр, бохир ус	1,881,700.00	1,917,458.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,030,700.00	15,930,670.00
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,499,650.00
210402	Тээвэр, шатахуун	8,680,700.00	8,679,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,400,000.00	1,308,520.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	450,000.00	448,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,994,500.00
2105	<b>Нормативт зардал</b>	27,150,600.00	26,563,040.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,116,600.00	14,556,190.00
210502	Хоол, хүнс	8,318,000.00	8,317,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,716,000.00	3,689,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,533,700.00	12,204,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,700,000.00	4,228,000.00
210602	Тавилга	6,190,700.00	5,334,000.00
210604	Урсгал засвар	2,643,000.00	2,642,650.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,450,000.00	1,388,000.00
210702	Дотоод албан томилолт	1,450,000.00	1,388,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	721,200.00	696,815.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,700.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,000.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,500.00	33,000.00
210807	Газрын төлбөр	120,000.00	97,640.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,670,000.00	4,612,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,670,000.00	4,612,600.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	540,000.00	540,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	540,000.00	540,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	540,000.00	540,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	372,914,400.00	368,954,232.42
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	324,268,400.00	324,267,972.42
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	324,268,400.00	324,267,972.42
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	29,409,600.00	29,409,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	29,409,600.00	29,409,600.00
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	19,236,400.00	15,276,660.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,236,400.00	15,276,660.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>10,905,065.55</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>110,951,945.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>110,951,945.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	85,151,945.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	787,962.00
210101	Үндсэн цалин	787,962.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	176,613.00
210201	Тэтгэврийн даатгал	176,613.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,573,510.00
210402	Тээвэр, шатахуун	3,573,510.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	73,393,160.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,393,160.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	238,500.00
210702	Дотоод албан томилолт	238,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,762,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,762,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	220,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	220,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	25,800,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	25,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,800,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>110,963,974.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	110,963,974.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,104,986.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,858,988.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,029.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөрөн сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөрөн сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Сумын ЭМТ нь эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 381.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөрөн сумын ЭМТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 119.2 сая төгрөгөөр буюу 24.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	<b>Б</b>	1.0	2.0	3=2-1
Мөнгөн хөрөнгө		-	10,917.1	10,917.1
Авлага		253.1	65,681.2	65,428.1
Урьдчилгаа		-	-	-
Бараа материал		38,757.6	88,913.5	50,155.9
Үндсэн хөрөнгө		443,950.8	436,675.3	(7,275.5)
<b>Нийт хөрөнгө</b>		<b>482,961.5</b>	<b>602,187.1</b>	<b>119,225.6</b>
Өр төлбөр		8,522.8	1,880.6	(6,642.2)
Засгийн газрын сан /Орон нутгийн сан		470,337.1	470,337.1	-
Өмнөх үеийн үр дүн		(6,157.1)	(6,157.1)	-
Тайлант оны үр дүн			125,867.8	125,867.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		10,258.7	10,258.7	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>		<b>482,961.5</b>	<b>602,187.1</b>	<b>119,225.6</b>
Нийт орлого /Үр дүнгийн тайлан		355,859.5	591,267.8	235,408.4
Нийт зардал /Үр дүнгийн тайлан		369,855.8	439,059.6	69,203.7

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 10.9 сая төгрөг болж өссөн нь тайлант онд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 65.7 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт орж ирээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 88.9 сая төгрөг болж 50.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь коронавируст халдварын үед хэрэглэх эм, хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлж ажиллаж байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 436.7 сая төгрөг болж 7.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь дээд шатны байгууллагаас 12.0 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн, батлагдсан төсвөөс 10.0 сая төгрөгийн худалдаж авсан үндсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 470.3 сая төгрөг байна. Тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 591.3 сая төгрөг болж, өмнөх оноос 235.4 сая төгрөгөөр буюу 66.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 465.4 сая төгрөг болж, өмнөх оноос 95.5 сая төгрөгөөр буюу 25.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна. Энэ нь коронавируст халдварын дэгдэлттэй холоотой илүү цагийн хөлс, урамшуулал, эм эмнэлгийн хэрэгсэл, хоол, эмч ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж, урамшуулал зэрэг зардлууд өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд орон нутгийн төсвөөс 29.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 19.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 324.3 сая төгрөг, нийт 372.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээс 324.3 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 15.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 29.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 358.0 сая төгрөгийг зарцуулж, 10.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Төсвийн гүйцэтгэл 96 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМДС-аас коронавируст халдвараар тусгаарлах байрны хэвтэн эмчлүүлэгчдийн санхүүжилт 71.8 сая төгрөг, дархлаажуулалтын вакцины санхүүжилт 11.4 сая төгрөг, эрүүл мэндийн ажиллагсдад олгох нэг удаагийн тэтгэмжийн санхүүжилт 25.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.9 сая төгрөг, нийт 110.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар анхаарах гол асуудал байхгүй байна

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 371.4 сая төгрөгийн 19 , зарлагын 68.9 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 88.0 сая төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй тухайн хэсэгт хамааралгүй мэдээлэл оруулж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн боловч зөрчил арилаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 80 хувь байна. Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал бүртгэгдээгүй.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 529.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.3 сая төгрөгийн алдааг залруулж, 528.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

##### 4.2.1 Залруулсан алдаа

ЭМДС-аас авах авлагыг 1.3 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсныг санхүүгийн тайланд залруулав.

##### 4.2.2 Албан шаардлага

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 371.4 сая төгрөгийн 19, зарлагын 68.9 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 88.0 сая төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй тухайн хэсэгт хамааралгүй мэдээлэл оруулж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн боловч зөрчил арилгаагүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

		/сая төгрөгөөр/									
д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Эрүүл мэндийн төв	1	1.3	1	1.3						
Дүн		1	1.3	1	1.3						
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Эрүүл мэндийн төв	1	528.3					1	528.3		
Дүн		1	528.3					1	528.3		
<b>Нийт дүн</b>		<b>2</b>	<b>529.6</b>	<b>1</b>	<b>1.3</b>			<b>1</b>	<b>528.3</b>		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 04

Дугаар 457/А2370449  
ХӨА-2022/139/НА-СТА-ТШ13

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 371.4 сая төгрөгийн 19, зарлагын 68.9 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 88.0 сая төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй, тухайн хэсэгт хамааралгүй мэдээлэл оруулж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг," 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд зохих мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, бүрэн мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын ЭМТ-ийн дарга Б.Жавзандулам, нягтлан бодогч Г.Хэрлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЕРКЕГҮЛ

Д.ОЮУНТУЯА